**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

# ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ХЭА-2025/130/НА-СТА-ТШ3**

Чингис хот 2025 он
Цахим хуудас: www.open.audit.mn

**Тэргүүлэх аудитор:** Ж.Ганбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390
Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkhegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг **khentii@audit.gov.mn** хаягаар авна уу

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.22 № 177

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.МӨНХДЭЛГЭР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан албан хаагчид олгох мөнгөн урамшууллаас 3,075.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй, ажилласан хугацаа 5 жил хүрээгүй 1 ажилтанд 8,184.0 мянган төгрөг, 3 ажилтанд олговол зохих дүнгээс 571.2 мянган төгрөгөөр илүү олгосон, ээлжийн амралтын цалинг 772.7 мянган төгрөгөөр дутуу олгосон, төвийн халаалтын шугамд холбогдон дулаан нийлүүлэх гэрээний дагуу халаалтын төлбөр төлдөг ч нэмэлтээр нүүрс худалдан авахад 4,900.0 мянган төгрөг зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн төсвөөс 1,235,854.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 13,382.1 мянган төгрөгийн орлого, туслах үйл ажиллагаанаас 0.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,148,152.5 мянган төгрөгийг зарцуулан, 94,284.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төрийн захиргааны албан тушаалд тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгож эхэлсэн байна.

232502176

**Аудитын гол асуудал**

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 344,182.7 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд алдаатай илэрхийлсэн 326,678.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 12,603.9 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 4,900.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 112 зорилтын хүрээнд 218 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 90.9 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **114,001,953.00** | **131,907,721.93** |
| **33** | **АВЛАГА** | - | 217,636.93 |
| **33100** | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 217,636.93 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 108,501,953.00 | 117,690,085.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 103,101,953.00 | 117,690,085.00 |
| **35410** | Бичиг хэргийн материал | 2,717,770.00 | 4,176,730.00 |
| **35420** | Аж ахуйн материал | 29,719,200.00 | 43,144,900.00 |
| **35440** | Түлш, шатах тослох материал | 6,000,000.00 | 2,940,000.00 |
| **35460** | Хүнсний материал | - | 234,000.00 |
| **35470** | Бусад хангамжийн материал | 64,664,983.00 | 67,194,455.00 |
| **35600** | Мал амьтад | 5,400,000.00 | - |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 5,500,000.00 | 14,000,000.00 |
| **36300** | Тэжээлийн нөөц | 5,500,000.00 | 14,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,950,612,483.38** | **3,033,135,967.56** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,950,612,483.38 | 3,033,135,967.56 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,903,460,483.38 | 1,980,649,967.56 |
| **39201** | Барилга, байгууламж, орон сууц | 1,678,321,888.60 | 1,943,821,888.60 |
| **39202** | Хуримтлагдсан элэгдэл | (548,414,452.78) | (666,924,286.30) |
| **39203** | Авто-тээврийн хэрэгсэл | 219,633,623.88 | 223,133,623.88 |
| **39204** | Хуримтлагдсан элэгдэл | (129,443,623.72) | (149,978,623.72) |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 428,117,609.34 | 481,620,571.27 |
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | (194,814,608.59) | (258,139,934.59) |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 73,289,466.52 | 80,809,466.52 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | (61,453,032.33) | (65,451,915.72) |
| **39214** | Бусад үндсэн хөрөнгө | 571,175,181.64 | 584,637,981.64 |
| **39215** | Хуримтлагдсан элэгдэл | (132,951,569.18) | (192,878,804.02) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,047,152,000.00 | 1,052,486,000.00 |
| **39301** | Програм хангамж | 580,000.00 | 580,000.00 |
| **39302** | Хуримтлагдсан элэгдэл | (580,000.00) | (580,000.00) |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | 1,047,152,000.00 | 1,052,486,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,064,614,436.38** | **3,165,043,689.49** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,064,614,436.38** | **3,165,043,689.49** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,064,614,436.38 | 3,165,043,689.49 |
| **511** | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 454,409,802.20 | 454,409,802.20 |
| **51101** | Өмч: - төрийн | 454,409,802.20 | 454,409,802.20 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,525,407,766.13 | 2,625,837,019.24 |
| **51210** | Өмнөх үеийн үр дүн | 2,525,407,766.13 | 2,525,407,766.13 |
| **51220** | Тайлант үеийн үр дүн | - | 100,429,253.11 |
| **51300** | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 84,796,868.05 | 84,796,868.05 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,064,614,436.38** | **3,165,043,689.49** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,156,913,743.84** | **1,568,595,562.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,149,291,311.84** | **330,065,261.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,149,291,311.84 | 330,065,261.93 |
| **120004** | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,149,291,311.84 | 330,065,261.93 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 200,000.00 |
| **1200045** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,149,291,311.84 | 329,865,261.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,007,622,432.00** | **1,238,530,301.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 100,895,732.00 | 2,675,901.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 99,096,732.00 | 2,325,901.00 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,799,000.00 | 350,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 906,726,700.00 | 1,235,854,400.00 |
| **132001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 906,726,700.00 | 1,235,854,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,037,577,277.22** | **1,468,166,309.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,031,027,277.22** | **1,461,166,309.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 974,921,711.48 | 1,312,671,300.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 369,285,510.59 | 582,755,440.27 |
| **210101** | Үндсэн цалин | 226,588,135.36 | 323,882,462.73 |
| **210102** | Нэмэгдэл | 79,898,202.02 | 169,445,794.81 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 2,370,998.93 | 2,415,000.00 |
| **210104** | Урамшуулал | 19,648,571.72 | 21,896,900.00 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | 40,779,602.56 | 65,115,282.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,325,600.00 | 74,087,045.59 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 31,532,400.00 | 50,677,534.32 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 3,694,200.00 | 5,843,751.78 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 3,026,110.96 | 3,653,932.43 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 739,900.00 | 2,740,478.07 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 7,332,989.04 | 11,171,348.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,667,105.27 | 56,518,951.15 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 14,586,675.27 | 19,379,605.15 |
| **210302** | Түлш, халаалт | 30,080,430.00 | 35,339,346.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | - | 1,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 68,455,874.40 | 83,566,013.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 10,543,400.00 | 9,954,540.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 32,525,200.00 | 22,557,875.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,598,174.40 | 4,255,820.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 324,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 171,000.00 | - |
| **210407** | Аж ахуйн материал худалдан авах зардал | 22,618,100.00 | 46,473,778.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,254,600.00 | 8,833,300.00 |
| **210502** | Хоол, хүнс | 1,254,600.00 | 8,833,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 29,176,850.00 | 5,510,000.00 |
| **210601** | Багаж, техник, хэрэгсэл | 2,484,000.00 | 3,310,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 26,692,850.00 | 2,200,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,202,000.00 | 16,418,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 10,202,000.00 | 16,418,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 131,431,719.00 | 186,421,373.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 128,845,500.00 | 184,032,510.00 |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | 621,000.00 | 550,000.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 397,412.00 | 526,279.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 165,500.00 | 177,500.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 612,000.00 | 355,000.00 |
| **210807** | Газрын төлбөр | 790,307.00 | 780,084.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 274,122,452.22 | 298,561,177.75 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,547,910.00 | 32,184,900.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 80,000.00 |
| **210903** | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 244,074,542.22 | 266,296,277.75 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,105,565.74 | 148,495,009.06 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,450,782.00 | 54,211,040.00 |
| **213204** | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 500,000.00 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 12,870,000.00 |
| **213207** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,307,782.00 | - |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 38,941,040.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,143,000.00 | 1,900,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12,654,783.74 | 94,283,969.06 |
| **213503** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,654,783.74 | 94,283,969.06 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,550,000.00** | **7,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,550,000.00 | 7,000,000.00 |
| **221001** | Их засвар | 400,000.00 | - |
| **223001** | Бусад хөрөнгө | 6,150,000.00 | 7,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,119,336,466.62** | **100,429,253.11** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,119,336,466.62** | **100,429,253.11** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,013,964,432.00** | **1,249,436,476.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,342,000.00** | **200,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 6,342,000.00 | 200,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,342,000.00 | 200,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,342,000.00 | 200,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,007,622,432.00** | **1,249,236,476.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 100,895,732.00 | 13,382,076.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 99,096,732.00 | 13,032,076.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,799,000.00 | 350,000.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 906,726,700.00 | 1,235,854,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 906,726,700.00 | 1,235,854,400.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **830,013,615.00** | **1,242,436,476.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **830,013,615.00** | **1,242,436,476.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **770,552,849.26** | **1,089,811,466.94** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 369,247,510.59 | 582,667,139.70 |
| 210101 | Үндсэн цалин | 225,285,905.95 | 350,978,192.63 |
| 210102 | Нэмэгдэл | 82,714,773.07 | 167,694,811.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,370,998.93 | 2,269,000.00 |
| 210104 | Урамшуулал | 19,245,746.72 | 16,654,040.55 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 39,630,085.92 | 45,071,094.89 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,325,600.00 | 74,200,483.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,526,900.00 | 50,753,671.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,699,700.00 | 5,853,826.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,026,110.96 | 3,658,469.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 739,900.00 | 2,745,015.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,332,989.04 | 11,189,498.99 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,701,255.27 | 47,404,601.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,586,675.27 | 19,379,605.15 |
| 210302 | Түлш, халаалт | 28,114,580.00 | 26,224,996.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 1,800,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 47,516,009.40 | 42,606,021.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,603,800.00 | 4,906,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,352,535.00 | 23,758,901.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,598,174.40 | 4,255,820.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 721,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,961,500.00 | 8,963,600.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 1,456,500.00 | 1,698,750.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,456,500.00 | 1,698,750.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 28,251,310.00 | 32,285,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,632,710.00 | 8,551,500.00 |
| 210602 | Тавилга | 630,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,988,600.00 | 18,733,500.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 10,202,000.00 | 16,418,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,202,000.00 | 16,418,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 168,560,034.00 | 230,111,872.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 166,015,815.00 | 227,338,009.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 621,000.00 | 550,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 397,412.00 | 526,279.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 165,500.00 | 177,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 570,000.00 | 740,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 790,307.00 | 780,084.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,292,630.00 | 62,419,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,923,630.00 | 60,871,600.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,369,000.00 | 1,548,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **59,460,765.74** | **152,625,009.06** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 46,805,982.00 | 58,341,040.00 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 12,870,000.00 |
| **213207** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,307,782.00 | - |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 38,941,040.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,498,200.00 | 6,530,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12,654,783.74 | 94,283,969.06 |
| **213503** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,654,783.74 | 94,283,969.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **183,950,817.00** | **7,000,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **183,950,817.00** | **7,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **183,950,817.00** | **7,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 183,950,817.00 | 7,000,000.00 |
| **223001** | Бусад хөрөнгө | 183,950,817.00 | 7,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(183,950,817.00)** | **(7,000,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 454,409,802.20 | 84,796,868.05 | 2,525,407,766.13 | 3,064,614,436.38 |
| **C02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **454,409,802.20** | **84,796,868.05** | **2,525,407,766.13** | **3,064,614,436.38** |
| **C04** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| **C05** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| **C06** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| **C07** | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| **C08** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **454,409,802.20** | **84,796,868.05** | **2,525,407,766.13** | **3,064,614,436.38** |
| **D01** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **454,409,802.20** | **84,796,868.05** | **2,525,407,766.13** | **3,064,614,436.38** |
| **D02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **454,409,802.20** | **84,796,868.05** | **2,525,407,766.13** | **3,064,614,436.38** |
| **D04** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| **D05** | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| **D06** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| **D07** | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| **D08** | Тайлант үеийн үр дүн | - | - | 100,429,253.11 | 100,429,253.11 |
| **D09** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **454,409,802.20** | **84,796,868.05** | **2,625,837,019.24** | **3,165,043,689.49** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,236,454,400.00 | 1,140,401,755.29 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,229,454,400.00 | 1,133,401,755.29 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,169,686,300.00 | 1,075,060,715.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 638,829,500.00 | 582,667,139.70 |
| **210101** | Үндсэн цалин | 321,330,300.00 | 325,094,198.86 |
| **210102** | Нэмэгдэл | 210,899,900.00 | 168,422,646.11 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 4,324,800.00 | 2,379,000.00 |
| **210104** | Урамшуулал | 26,652,000.00 | 21,896,900.00 |
| **210105** | Гэрээт ажлын хөлс | 75,622,500.00 | 64,874,394.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 81,105,400.00 | 72,796,807.44 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 55,151,700.00 | 50,753,671.82 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 6,488,400.00 | 5,853,826.78 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 3,244,200.00 | 2,863,778.63 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 3,244,200.00 | 2,863,778.63 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 12,976,900.00 | 10,461,751.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,977,500.00 | 47,404,601.15 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 22,768,100.00 | 19,379,605.15 |
| **210302** | Түлш, халаалт | 25,409,400.00 | 26,224,996.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,101,200.00 | 40,532,120.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 4,614,200.00 | 4,591,700.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 22,000,000.00 | 22,000,000.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,478,200.00 | 4,255,820.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут | 1,045,000.00 | 721,000.00 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,963,800.00 | 8,963,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,807,100.00 | 1,698,750.00 |
| **210503** | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,807,100.00 | 1,698,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 32,559,200.00 | 32,285,000.00 |
| **210601** | Багаж, техник, хэрэгсэл | 8,559,200.00 | 8,551,500.00 |
| **210602** | Тавилга | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 19,000,000.00 | 18,733,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 18,500,000.00 | 16,418,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 18,500,000.00 | 16,418,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 242,381,600.00 | 218,838,697.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 238,258,600.00 | 216,064,834.00 |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 622,800.00 | - |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 550,000.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 536,400.00 | 526,279.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 245,600.00 | 177,500.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 740,400.00 | 740,000.00 |
| **210807** | Газрын төлбөр | 963,500.00 | 780,084.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 63,424,800.00 | 62,419,600.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 61,875,900.00 | 60,871,600.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,548,900.00 | 1,548,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 59,768,100.00 | 58,341,040.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 59,768,100.00 | 58,341,040.00 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,870,000.00 | 12,870,000.00 |
| **213208** | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 40,284,000.00 | 38,941,040.00 |
| **213209** | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,614,100.00 | 6,530,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,000,000.00** | **7,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| **223001** | Бусад хөрөнгө | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,236,454,400.00 | 1,141,805,430.94 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,235,854,400.00 | 1,141,605,430.94 |
| **132001** | Орон нутгийн төсвөөс | 1,235,854,400.00 | 1,141,605,430.94 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 600,000.00 | 200,000.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 200,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **13,382,076.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,382,076.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 13,382,076.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 2,073,901.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 315,000.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 1,758,901.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,273,175.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,273,175.00 |
| 2133 | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **35,000.00** |
| **213503** | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 35,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 13,382,076.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,382,076.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,032,076.00 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 350,000.00 |
| Дансны код | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **13,382,076.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,382,076.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 13,382,076.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 2,073,901.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 315,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 326,678.8 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. Засварын ажил дуусаагүй ажлын урьдчилгаа 13,200.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй, зардалд хаасан;
2. Тайлан оны үндсэн хөрөнгийн элэгдлийг 5,119.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.
3. ОНХС-аар хийгдсэн 308,359.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй орхигдуулсан алдааг залруулав.

Аудитаар нийт 16,932.4 мянган төгрөгийн зөрчил  илэрснээс, 4,900.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 12,603.9 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

### 5.1 Төлбөрийн акт

1. Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас 3,075.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй;
2. Ээлжийн амралт олгох хоногийг тушаал шийдвэрээс 6 хоногоор зөрүүтэй тооцож 1 албан хаагчийн ээлжийн амралтын цалинг 772.7 мянган төгрөгөөр дутуу олгосон;
3. Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан хугацаа 5 жил хүрээгүй 1 албан хаагчид 8,184.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон;
4. Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан албан хаагчид мөнгөн урамшууллыг 3 ажилтанд 571.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага

1. Төвийн халаалтын шугамд холбогдон дулаан нийлүүлэх гэрээний дагуу халаалтын төлбөр төлдөг ч нэмэлтээр нүүрс худалдан авахад 4,900.0 мянган төгрөг зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан зөрлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

### 5.2 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| УТЗ-ын бүртгээгүй | 1 | 13,200.0 | | | 1 | 13,200.0 | 1 | 8,000.0 | | | | |
| Үндсэн хөрөнгө зөрүүтэй | 1 | 5,119.0 | | | 1 | 5,119.0 | 1 | 5,850.5 | | | | |
| ҮХ-ийг орлого аваагүй | 1 | 308,359.8 | 1 | 308,359.8 | | | 1 | 308,359.8 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | **3** | **326,678.8** | 1 | 308,359.8 | **2** | **18,319.0** | **3** | **326,678.8** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалин зөрүүтэй олгосон | 3 | 9,528.2 | 3 | 9,528.2 | | | | | | | | |
| Хууль тогтоомжийн хэрэгжилт | 1 | 3,075.7 | 1 | 3,075.7 | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **12,603.9** | **4** | **12,603.9** | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| **Зөрчилгүй** | 0 | 0 | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| **Зөрчилгүй** | 1 | 4,900.0 | | | 1 | 4,900.0 | | |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22 Дугаар 97-ХЭА-2025/130/НА-СТА-ТШ3 Чингис хот
А 2390049

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төвийн халаалтын шугамд холбогдон дулаан нийлүүлэх гэрээний дагуу халаалтын төлбөр төлдөг ч нэмэлтээр нүүрс худалдан авахад 4,900.0 мянган төгрөг зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Загдхүү нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.ЕРКЕГУЛ

232504097

Монгол улс, Чингис хот, 4-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, 7056211

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар 85-2025/130/НА-СТА-ТШЗ Чингис хот

А 2390049

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан хугацаа нь 5 жил хүрээгүй 1 албан хаагчид 8,184.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ы өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1-д Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал авна” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэслэлгүй олгосон мөнгөн урамшууллын 8,184.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Загдхүү нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

232505085

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар 83-ХЭА-2025/130/НА-СТА-ТШЗ Чингис хот
А2390049

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас 3,075.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-т "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй татварын 3,075.7 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Загдхүү нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

232505083

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар 81-ХЭА-2025/130/НА-СТА-ТШ3 Чингис хот
А 2390049

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй ажилласан 3 ажилтанд мөнгөн урамшууллыг 571.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ы өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.3-д “Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү тооцож олгосон мөнгөн урамшууллын 571.2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Загдхүү нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

232505081

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар 82-ХЭА-2025/130/НА-СТА-ТШ3 А2390049 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын цалинг 1 ажилтанд тушаал шийдвэрээс 6 хоногоор зөрүүтэй тооцож, 772.7 мянган төгрөгийг дутуу олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 2.13-д ”Ажилтны ажилласан хугацааг харгалзан ээлжийн нэмэгдэл амралтыг дор дурдсанаар тооцож олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дутуу тооцож олгосон 772.7 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг тухайн ажилтанд нөхөн олгох.

2. Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Загдхүү нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

232505082

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112